

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

**МОНГОЛЫН СЭТГҮҮЛ ЗҮЙН ТҮҮХИЙН СУДЛАЛЫГ ШИНЭ ШАТАНД
ГАРГАСАН ЭРДЭМТЭН**

(Монгол Улсын Соёлын Гавьяат Зүтгэлтэн, Шинжлэх ухааны доктор (Sc.D),
профессор Л.Норовсүрэнгийн 70 насны ойд)

М.Зулькафиль*

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, шинжлэх ухааны доктор (Sc.D)

Оршлын оронд Монголын сэтгүүл зүйн судлалыг, тэр дундаа ОНМХ-ийн түүхийн судалгааг багш, шавь хоёр эрдэмтэнгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Энэ бол Монголын сэтгүүл зүй судлалын тулгын чулууг тавьсан, манай орны сэтгүүл зүйн анхны эрдэмтэн, анхны нэг сэдэвт бүтээлийг зохиогч, нэрт судлаач, түүхийн шинжлэх ухааны доктор Гэндэнжамцын Дэлэг ба түүний гарын шавь нарын нэг, багшийнхаа судалж байсан сэдвийг цаг хугацаа, орон цайн хувьд гүнзгийрүүлэн судалж “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” I, II, III боть (2000, 2001, 2003), “Монголын нийтлэл” I, II, III боть (2004, 2005, 2007) зэрэг томоохон бүтээл туурвисан сэтгүүл зүйн доктор, хэлбичгийн шинжлэх ухааны доктор, профессор, МУСГЗ Ломбын Норовсүрэн юм.

Манай нийтлэлчид хөрөг нийтлэл, дурсамж тэмдэглэл бичихдээ “хос морьтой, тод мөртэй” гэдэг хэллэгийг ашиглах нь түгээмэл юм. Тэгвэл би Л.Норовсүрэн докторыг Монголын сэтгүүл зүй дэх “гурвалсан морьтой, хусавч арилахгүй мөртэй” хүн гэж

хэлэх нь зүйд нийцнэ гэж боддог. Учир нь Л.Норовсүрэн судлаач, багш сурган хүмүүжүүлэгч, нийтлэлч хүн юм. Тэрээр өөрийнхөө сэтгүүлч болох гараагаа Говь-Алтай аймгмийн “Алтайн хөгжил” сонинд сурвалжлагчийн ажлаас эхэлж төв, орон нутгийн сонинд 5000 орчим мэдээ, сурвалжлага, найруулал, тэмдэглэл, гэрэл зураг нийтлүүлжээ. Түний бичсэн “Газар бид хоёр”, “Сэтгэлийн авиа” найруулал нь улсын хэмжээний уран бүтээлийн уралдаанд байр эзэлж, шилдэг нийтлэл, гэрэл зургаараа 10 гаруй удаа төвийн сонин, сэтгүүлийн оны шилдэг бичлэгийн шагналыг хүртэхийн зэрэгцээ “Ус хөтөлсөн хүн” (1983), “Сэтэрт халиун”, “Гурван гүрэнд зорчсон тэмдэглэл” (2011) өгүүллэг, найруулал, аян замын тэмдэглэлийн ном, “Цэлмэг тэнгэрийн эзэд” (1986), “Модны хээ” (1988) зэрэг баримтат киноны зохиолыг бичжээ. Энэ бол Л.Норовсүрэн хэр зэрэг сэтгүүлч, нийтлэлч болохын яруу тод баталгаа юм.

Профессор Л.Норовсүрэн 1982 оноос МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимд 36 жил тасралтгүй багшилж, Монгол Улсын үе үеийн сэтгүүлч боловсон

хүчнийг бэлтгэх, сэтгүүл зүйн сургалтын хөтөлбөрийг нийгмийн өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох, сэтгүүл зүйн тэнхимийн материаллаг баазыг бэхжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, мэргэжлийн гол гол хичээлүүдийн сурах бичгийг бэлтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулж яваа манай цөөхөн багш, судлаачдын нэг юм. Өнөөдөр Л.Норовсүрэн багшийн бичсэн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм”, “Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл”, “Редакторлах зүйн онол, практик”, “Иргэний сэтгүүл зүй”, “Фото сэтгүүл зүй”, “Телевизийн сэтгүүл зүй”, “Радио сэтгүүл зүй” зэрэг бүтээлүүдийг манай орны сэтгүүлч бэлтгэж буй бүх их, дээд сургуульд үндсэн сурах бичгээр сэтгүүл зүйн янз бүрийн сэдвийн хүрээнд бичсэн бусад судалгааны бүтээлүүдийг магистр, докторын түвшний сургалтанд өргөн ашиглаж байна. Түүнчлэн проф. Л.Норовсүрэн сэтгүүл зүйн сургалтын чанарыг сайжруулахад чиглэгдсэн хэд хэдэн төслийн ахлагч болон гүйцэтгэгчээр ажиллаж, 2004 онд хэсэг эрдэмтэн, багш судлаачийн хат боловсруулсан “Сэтгүүлч” мэргэжлийн стандарт нь Стандарт, хэмжил зүйн үндэсний зөвлөлөөр батлагдсан анхны дээд боловсролын мэргэжлийн хоёр стандартын нэг юм. Тиймээс энэхүү стандарт нь Монгол Улсын БСШУЯ, Сэтгүүлчдийн мэргэжлийн байгууллагууд, МУИС болон сэтгүүлч боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургуулиудын зүгээс өндөр үнэлэлт авсан юм. Үүнд Л.Норовсүрэн багшийн хувь нэмэр асар их гэдгийг онцлон хэлэх хэрэгтэй.

Доктор Л.Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн судлал, онолын сэтгэлгээг хөгжүүлэхэд үнэлж баршгүй томоохон хувь нэмэр оруулсан эрдэмтэн судлаач юм. Үүнийг дараах хэдэн

тоо баримтаас харж болно. Тэрээр сэтгүүл зүйн судалгааны ажлыг төгсөх ангийн оюутан байсан цагаасаа эхэлж өнөөдөр хүртэл тасралтгүй үргэлжлүүлж байгаа бөгөөд энэ хугацаанд нэг сэдэвт зохиол, сурах бичиг, гарын авлага 40-ийг бичиж, бусдын 23 номыг хянан найруулж, гадаад, дотоодын нөлөө бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлүүдэд 60 гаруй судалгааны өгүүлэл нийтлүүлж, улсын болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд 30 орчим илтгэл тавьж хэлэлцүүлсэн байна. Түүнчлэн түүний суурь судалгааны нэг болох “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм”-ын гурван боть, “Монголын нийтлэл” гурван боть бүтээл нь тус тус ӨМӨЗО-д монгол бичгээр хэвлэгджээ. Дээрх бүтээлүүд Монголоос сэтгүүл зүйн чиглэлээр гадаадад хэвлэгдсэн анхны суурь судалгааны бүтээл болсон бөгөөд БНХАУ-ын монгол хэлт үндэстнүүдийн их, дээд сугуулиудын багш, оюутны гарын авлага болсноороо чухал ач холбогдолтой юм.

Миний бие энэхүү сэтгүүлд зориулж бичсэн багахан өгүүлэлд Л.Норовсүрэн докторын судалгааны бүх бүтээлийн талаар өгүүлэх боломжгүй учраас эрдмийн зэрэг горилж бичсэн хамгийн гол хоёр бүтээл болох докторын болон шинжлэх ухааны докторын ажлын удирдагч, зөвлөхөөр ажилласны хувьд зохиогч энэхүү хоёр нэг сэдэвт бүтээлээрээ Монголын сэтгүүл зүйн судлалд ямар хувь нэмэр оруулсан талаар тогтож ярихыг хичээлээ. Нөгөө талаар проф. Л.Норовсүрэнгийн бүтээлүүдийн талаар доктор Т.Баасансүрэн “Монголын сэтгүүл зүйн судлал шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Ломбын Норовсүрэн” (2013) нэг сэдэвт бүтээлд, академич Х.Сампилдэндэв,

нэрт сэтгүүлч, доктор Л.Түдэв, ахмад сэтгүүлч, МУСГЗ Х.Цэвлээ, ӨМИС-ийн профессор Бүрээчин Дархан, ӨМӨЗО-ы сэтгүүлч Буянтогтох, зохиолч, сэтгүүлч, МУСГЗ Д.Жамьян нар зохиогчийн номын оршил болон бие даасан өгүүллүүдэд дэлгэрэнгүй бичсэн тул зарим санааг давхардуулахгүй байхын тулд зөвхөн эрдмийн зэрэг горилж бичсэн хоёр бүтээлийн талаар тусгайлан өгүүлэх нь зөв гэж үзсэн хэрэг юм.

Нэг. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлуудын талаарх чамбай бүтээл

Хэл бичгийн шинжлэх ухааны доктор, профессор Л.Норовсүрэн МУИС-д 36 жил багшлах хугацаандаа сэтгүүл зүйн түүх, онол, практикийн чиглэлээр олон тооны бүтээл туурвисныг дээр дурдсан. Түүний дотор Монголын сэтгүүл зүйн түүхийн асуудлыг үндсэн сэдэв болгон олон жил уйгагүй судалж “Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд” (1999), “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” I, II, III боть (2000, 2001, 2003), “Монголын нийтлэл” I, II, III боть (2004, 2005, 2007), “XX зууны эхэн үеийн монгол сэтгүүлчид” (2012) зэрэг томоохон бүтээл туурвисан билээ. Дээрх бүтээлүүдэд Монголын сэтгүүл зүйн түүхийг бүрэн хэмжээгээр, бүх бүрдэл хэсгүүдийг нь хамруулан авч үзсэн юм. Үүнийг онцлон тэмдэглэхийн учир нь Л.Норовсүрэнгийн шинжлэх ухааны докторын зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл нь түүний олон жилийн хөдөлмөрийн үр дүн бөгөөд судалгааны томоохон бүтээл туурвисан туршлага, олж судалсан арвин баялаг эх хэрэглэгдэхүүндээ тулгуурлан бичсэн даацтай ажил болсныг хэлэх гэсэн хэрэг.

Судлаач Л.Норовсүрэнгийн шинж-

лэх ухааны докторын зэрэг горилж бичсэн “Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд” (2004) нэг сэдэвт бүтээл нь үндсэн гурван бүлэг, 19 хэсгээс бүрдсэн бөгөөд “Монголын сэтгүүл зүйн түүхэн хөгжлийн асуудлууд” сэдэвт нэгдүгээр бүлэгт манай оронд сэтгүүл зүй үүсэх нөхцөл бүрэлдсэн онцлог шинж, ууган тогтмол хэвлэлүүдийн үндсэн агуулга, онцлог, мөн хувьсгалт хэвлэлийн үүсэл, залгамж чанар, өнгөрсөн зууны 20-30-аад оны тогтмол хэвлэлийн шинж чанар, 40-50-иад оны сэтгүүл зүйн үндсэн сэдвүүд, 60-70-аад оны сэтгүүл зүйд бүтээн байгуулах үйлсийг тусгаж байсан онцлог, ОНМХ-ийн систем бүрэлдсэн зэрэг асуудлуудыг тусгаж, Монголын сэтгүүл зүйн 90 гаруй жилийн түүхэн хөгжлийг түүх, онол, практикийн үүднээс тусгаж зангилаа асуудлуудад дүн шинжилгээ хийжээ. Судлаач дээрх асуудлуудыг тусгахдаа Монголын сэтгүүл зүй үүсэхэд нөлөөлсөн хүчин зүйлс болон нийгэм-улс төрийн урьдач нөхцөлийг нэлээд дэлгэрэнгүй авч үзэж, сэтгүүл зүй үүссэн нь ард түмний оюуны соёлын олон зуун жилийн уламжлал, туршлагын үр дүн болохыг онцлон харуулж, монголчуудын ном хэвлэн барлаж ирсэн туршлага, утга зохиолын арвин баялаг өв сан, сонин сэтгүүл эрхлэн гаргах дадал чадвар бүхий үндэсний сэхээтэн төрөн гарч, цөөн ч гэсэн уншигчтай болсон зэрэг нь сэтгүүл зүй үүсэх оюун санааны үндэс болсон гэсэн үндэслэл сайтай дүгнэлт хийсэн юм. Түүхийн шинжлэх ухааны доктор, МУСГЗ Б.Лигдэн “...ахар богино хугацаанд ээдрээтэй замыг туулж, арвин их туршлага хуримтлуулж, хөгжингүй сэтгүүл зүйн жишигт ойртож очсон үндэсний сэтгүүл зүйн давшингуй хөгжил, өвөрмөц онцлогийг судалгаа

шинжилгээний үр дүнд үндэслэн гаргаж тавьсанд энэ бүлгийн ач холбогдол оршиж байна. Монголын сэтгүүл зүйн өмнөх үзэгдлүүд, нийтлэлийн уламжлалын асуудал, сэтгүүл зүй үүссэн онцлог, анхдагчид болон сэтгүүл зүйн түүхийн үечлэлийн талаар үндэслэл бүхий нотолгоо дүгнэлт гаргасны зэрэгцээ сэтгүүл зүйн хөгжлийг түүхэн зүйн үүднээс бодитой харж, үе үеийн сэтгүүлчдийн гүйцэтгэсэн үүрэг, үлдээсэн өв уламжлалыг зохих байранд нь тавьж эрдэм шинжилгээний эргэлт, сургалтын үйл ажиллагаанд оруулсанд нэг сэдэвт бүтээлийн бас нэг ач холбогдол оршиж байна”¹ гэж дүгнэсэн нь дээрх миний саналыг давхар нотолж байгаагийн илрэл юм.

Багш, судлаач Л.Норовсүрэн Монголд сэтгүүл зүй үүссэн байдлыг бэлтгэл болон үндсэн гэсэн хоёр үед хуваан судалж, бэлтгэл үед сэтгүүл зүй нийгмийн оюуны амьдралын бодит үзэгдэл болохоос өмнөх үеийн мэдээлэл солилцох хэлбэрүүд, Манж, Хятад, Орос зэрэг орноос Монголд зориулан гаргаж байсан тогтмол хэвлэлүүдийг оруулжээ. Үндэсний сэтгүүл зүйн түүхийг Монголын үндэсний дэвшилт ардчилсан тогтмол хэвлэлийн үе (1913-1920), Монголын хувьсгалт нууц хэвлэлийн үе (1919-1920), Монгол Улсад социалист нийгэм байгуулахын төлөө тэмцлийн үеийн сэтгүүл зүй (1921-1990), Монголын чөлөөт ардчилсан сэтгүүл зүй (1990 оноос хойш) гэж үечилсэн нь урьд өмнө энэ талаар судалгаа хийж байсан эрдэмтдээс арай өөр, нэн шинэлэг дүгнэлт гэдгийг онцлон тэмдэглэж байна. Үүнээс үзэхэд проф. Л.Норовсүрэнгийн энэхүү бүтээл нь доктор Г.Дэлэг багшийн сэтгүүл зүйн түүхийн судалгааны бүтээлүүдээс нэгд, Монголын сэтгүүл

зүйн өмнөх үзэгдлүүдийг судалж, сэтгүүл зүйн түүхийн судалгааг цоо шинэ баримт мэдээллээр баяжуулснаар, хоёрт, сэтгүүл зүйн түүхийн үечлэлийн асуудлыг урьд өмнөх судлаачдаас өөрөөр авч үзээд үндэслэл сайтай нотолгоо гаргаж тавьснаар, гуравт, монголын сэтгүүл зүйн 1970 оноос хойшхи 40-өөд жилийн түүхийг нэмж судалж, урьд өмнө судалгааны эргэлтэнд ороогүй шинэ баримт мэдээллийг анх удаа судалгааны эргэлтэнд оруулснаараа ялгаатай юм.

Профессор Л.Норовсүрэн Монголын ууган тогтмол хэвлэл болох “Шинэ толь хэмээх бичиг”, “Нийслэл хүрээний сонин бичиг” зэрэг сонинуудын улс төрийн чиглэл, нийтлэлийн агуулга, төрөл зүйл, онцлогийг нэлээд нухацтай судалж, анхны тогтмол хэвлэлийн соён гэгээрүүлэгч, илчлэн шүүмжлэгч чиглэлийг тодорхой жишээ баримтад тулгуурлан гаргахын хамт, тус сонины ач холбогдлыг:

- Тогтмол хэвлэлийн уламжлалт хэлбэр болох сонин, сэтгүүлийн аль алийг монголчууд муугүй гаргаж чадахыг үзүүлж, манай улсад сэтгүүл зүйн үндсийг тавьсан,
- Үндэсний тогтмол хэвлэл үүссэн нь феодалын бурангуй ёс, харийн колонилогчдыг эсэргүүцэн, жирийн олны эрх ашгийг хамгаалсан үндэсний эрх чөлөөний тэмцлийн салшгүй хэсэг болсон,
- Монголын ард түмнийг олон үеийн хоцрогдлоос ангижруулах зорилгоор шинжлэх ухааны эрдэм мэдлэг түгээн дэлгэрүүлж, гэгээрүүлж боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэсэн,
- Хамгийн чухал нь Монгол оронд сэтгүүл зүйн үндсийг тавихдаа тухайн хүнд бэрх нөхцөлд хэнээс ч айлгүй, үнэн үгийг шууд хэлж, харьцангуй

чөлөөт хэвлэлийн шинжтэй ажиллаж байсан зэрэг үндсэн дөрвөн зүйлээр тодорхойлсон нь үндэслэл сайтай, шинэ санаа болжээ.

Судлаач Л.Норовсүрэнгийн нэг сэдэвт зохиолын хамгийн сонирхолтой бөгөөд урьд өмнө Монголын сэтгүүл зүйн судлалд маш бага хөндөгдсөн асуудлыг тусгасан бүлэг бол “Монголын сэтгүүл зүйн онол, ур чадварын хөгжил, төлөвшил” хэмээх хоёрдугаар бүлэг юм. Энэ бүлэгт сэтгүүл зүйн дэлхий дахинд хүлээн зөвшөөрөгдсөн онол болон үзэл суртлын хэв маягууд, Монголын сэтгүүл зүйд тэдгээрийн нөлөө хэрхэн туссан тухай асуудлыг авч үзэж, үүнийг сэтгүүл зүйн онол, түүхэн хэв маягуудын тухай асуудлыг гүнзгий судалж, мэргэжилтнүүдийн зүгээс өндөр үнэлэлт авч чадсан Америкийн нэрт эрдэмтэн Жон Меррилл, Оросын судлаач Е.П.Прохоров нарын онол, үзэл баримтлалд тулгуурлан тайлбарлажээ. Доктор, профессор Жон Мерриллийн сэтгүүл зүй анх үүссэн ХҮИ зууны эхэн үеэс өнөөг хүртэл дэлхий дахины сэтгүүл зүй эрх мэдэлтний, коммунист, эрх чөлөөний, нийгмийн хариуцлагын гэсэн онолын дөрвөн хэв маягийг дамжиж ирсэн гэсэн дүгнэлтэнд тулгуурлан дээрх хэв маягуудыг нэгбүрчлэн тайлбарлаж, утга агуулгыг дэлгэрэнгүй гаргаж, Е.П.Прохоровын феодалын хаант засгийн, шашны клерикал үзлийн, хөрөнгөтний, социалист гэж ангилсныг “нэр томъёоны хувьд бага зэрэг зөрөөтэй боловч агуулга нь ойролцоо байна” гэсэн сонирхолтой, бас нэлээд зоригтой дүгнэлт хийж чадсан нь судлаачийн багагүй хүч хөдөлмөр, эрэл хайгуулын үр дүн юм. Үүний үндсэн дээр судлаач “Монголын сэтгүүл зүй дээрх дөрвөн онолын аль алийг нь

удирдлага болгон хөгжиж ирсэн... Сэтгүүл зүй үүссэн нийгэм, цаг үеийн байдлаас шалтгаалан Монголд эрх мэдэлтний онол хэрэгжих бололцоогүй байв. Харин 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа коммунист онол сэтгүүл зүйд хүчтэй нэвтэрсэн юм. Энэ онолыг удирдлага болгож байсан далан жилд сэтгүүл зүйн зонхилох арга туршлага хуримтлагдсан нь Монголын сэтгүүл зүйн онцлог юм.

1990 оны ардчилсан хувьсгалын дараа Өрнөдийн өндөр хөгжилтэй орнуудад нэгэнт төлөвшсөн эрх чөлөөний онолыг шууд өвлөн авахыг цаг үе шаарджээ. Энэ онолыг хэрэгжүүлж эхэлж байхад нийгмийн хариуцлагын онол хамт яригдах болсон нь Монголын орчин үеийн сэтгүүл зүйн онолын сэтгэлгээнд гарсан бас нэг шинэ хандлага мөн. Хуучин хоёр системийн аль алины үнэт зүйлийг хадгалсан шинэ соёл иргэншлийн нийтлэг энэрэнгүй сэтгүүл зүйг хөгжүүлэх явдал Монголын сэтгүүл зүйн ирээдүйн чиглэл байх болно”² гэсэн нэн шинэлэг, онол, практикийн өндөр ач холбогдолтой дүгнэлт хийснийг сэтгүүл зүйн багш, судлаачийн хувьд бүрэн дэмжиж байна.

Мөн энэ бүлэгт сэтгүүлчийн уран чадварын шалгуур, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга хэлбэрийн нэгдлийг хангадаг гол хүчин зүйл бологч бичлэгийн зүйл бүрт онолын тодорхойлолт өгч, бичиж ирсэн уламжлал, шинэчлэлийн асуудлыг онол-практикийн үүднээс үнэлэн дүгнэж, бичлэгийн хэлбэрийн талаарх өөрийн гэсэн тодорхойлолтыг өгч, төрөл зүйлийн ижил төстэй, ялгаатай талуудыг зааж, шинж тэмдгүүдийг тодорхойлохын хамт сэтгүүл зүйн өмнөх үзэгдлийн хүрээнд багтдаг мэдээлэл солилцох уламжлалт

аргууд болох аман нийтлэл, хуучны уран зохиол дахь нийтлэлийн шинж, үг зохиол, заргын бичиг, захидал зэргийн талаар дэлгэрэнгүй өгүүлж, үүнийг В.Инжиннаши, З.Агваанбалдан, Л.Агваанхайдав, Д.Данзанравжаа нарын бүтээлийн жишээн дээр харуулж урьд өмнө эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэнд ороогүй олон шинэ баримт, мэдээллийг ашиглаж, өөрийн гэсэн үнэлэлт дүгнэлт өгсөн нь түүх, онол, практик төдийгүй бичлэгийн арга зүйн хувьд онцгой чухал гэдгийг тэмдэглэх хэрэгтэй юм. Энэ асуудлын талаар шинжлэх ухааны доктор (Sc.D), МУСГЗ Ш.Цэнд-Аюуш "Зохиогч сэтгүүл зүйн өнгөрсөн үеийн үзэгдлүүдэд дүгнэлт хийхдээ зөвхөн түүхийн сурвалжид тулгуурласны дээр өмнөх үеийн бүтээлүүд шиг үзэл сурталд автагдах, нэг талыг барьж туйлшрах, сэтгэлийн хөдлөлдөө хөтлөгдөх зэрэг эндэгдлээс тойрч чадсан нь бүтээлийн шинжлэх ухаанч чанарыг өргөж байна"³ гэсэн дүгнэлт хийсэнтэй санал нэг байна.

Судлаач Монголын сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйлийн хөгжил, уламжлал, шинэчлэлийг Ц.Дамбадорж, Г.Навааннамжилаас эхлээд Т.Баасансүрэн, Ш.Цэрэнпил хүртэлх үе үеийн нэрт нийтлэлч, сэтгүүлчдийн уран бүтээлд дүн шинжилгээ хийх замаар харуулахын хамт сэтгүүл зүйн судалгаа, сургалтын байдал, чиг хандлагыг тодорхой жишээ баримтад тулгуурлан харуулсан нь манай сэтгүүл зүйн онол, практикийн нэгдэл, харилцан нөлөөллийг ойлгох, тодорхой мэдлэг, төсөөлөл олж авахад чиглэгдсэн томоохон алхам болжээ.

Өнгөрсөн зууны далаад оны үед нийгмийн оюуны амьдралын бие даасан салбарын хэмжээнд хүрч, мэдээллийн цогц систем болж бүрдсэн ОНМХ-ийн тогтолцоо 1990-ээд оноос

задарч, ХМХ-ийн шинэ бүтэц, хэв маяг бий болоход нөлөөлсөн хүчин зүйл, шалтгааныг зохиогч нэлээд дэлгэрэнгүй тайлбарлаж, орчин үеийн ОНМХ-ийн систем нь: "1. Төр, засгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 2. Улс төрийн, нам хүчнүүдийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 3. Олон нийтийн байгууллагуудын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 4. Салбарын хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 5. Пүүс, компани, аж ахуйн нэгжийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 6. Хувь хүний хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 7. Гадаадын хөрөнгө оруулагчидтай хамтарсан хэвлэл мэдээллийн хэрэгсэл, 8. Гадаадын харъяалалтай хэвлэл мэдээллийн хэрэгсэл"⁴ гэсэн бүтэцтэй гэж дүгнэсэн нь нэн оновчтой, зөв ажиглалт юм.

Нэг сэдэвт бүтээлийн "Ардчилсан нийгэмд шилжих үеийн сэтгүүл зүйн тулгамдсан асуудлууд" хэмээх гуравдугаар бүлэгт ардчилсан нийгмийн хөгжлийн он жилүүдэд Монголын сэтгүүл зүйн зорилго, үүрэг, бодлого, чиглэл, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хэлбэр, ур чадварт гарсан өөрчлөлт, шинэчлэлийг тодорхой жишээ баримтад тулгуурлан харуулжээ. Судлаачийн хийсэн "Өөрчлөн байгуулалтын үеийн Монголын сэтгүүл зүйн чухал ололтууд нь нэгдүгээрт: хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийг шинэ сэтгэлгээ, дэвшилт арга барилд сургаж, эх орон, ард түмний эрх ашгийн төлөө шударга үнэн үг хэлэх эр зоригийг хурцалж өгсөн, хоёрдугаарт: сэтгүүл зүйн туршлагыг баяжуулж, ялангуяа мартагдах шахаж байсан илчлэн шүүмжлэх чиглэлийг дахин сэргээж, ингэснээр олон түмний идэвхийг бадраасан, гуравдугаарт: өөрчлөлт шинэчлэл зайлшгүй бөгөөд тэр нь манай нийгмийн амьдралд хуралдсан ужиг хямрал, зогсонги байдлаас эх

үндэстэй болохыг олон нийтэд ухамсарлуулж чадсан, дөрөвдүгээрт: хамгийн чухал нь социализмыг засч сайжруулах хүрээнд хийгдэж байсан өөрчлөн байгуулалтыг улс төрийн тайван замын хувьсгал болгон хувиргах сэтгэл зүйн бэлтгэлийг хангаж өгсөн зэргээр тодорхойлогдоно”⁵ гэсэн чухал дүгнэлт хийснийг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Энэ бүлэгт Монгол оронд чөлөөт хэвлэл бүрэлдэн төлөвших явцад учирч буй саад бэрхшээл, тулгамдсан асуудал, чөлөөт хэвлэл хөгжих нийгэм, улс төр, эдийн засаг, эрх зүйн орчны тухай авч үзээд улс орон чөлөөт хэвлэлтэй байгаагийн гол шалгуур нь эдийн засгийн хувьд бие даасан, төр засгаас хараат бус, улс төрийн нам, хүчнүүдийн нөлөөнөөс ангид, үйл ажиллагааных нь эрх зүйн орчин бүрэлдсэн байх явдал гэж үзээд олон ургальч үзлийг хүлээн зөвшөөрдөг, ил тод байдлын индэр болж чаддаг, улс төрийн аль нэг үзэл бодлыг дагаж туйлширдаггүй бөгөөд төр, засгийн үйл ажиллагаанд олон түмний хяналт тавих бололцоог хангаж, сөрөг хүчний байр сууринаас хандаж чаддаг болох нь чөлөөт хэвлэлийн төлөвшилтийн чухал нөхцөл мөн гэж дүгнэсэн нь шинэлэг санаа юм.

Судлаач чөлөөт хэвлэлийн талаарх эрдэмтдийн үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж, чөлөөт шүүмжлэлийн онол, сэтгүүл зүйн дотоод эрх чөлөөний онол, чөлөөт сонголтын онолын талаар дэлгэрэнгүй өгүүлж, эдгээр онол, үзэл баримтлал болон Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний харти, тунхаглал, бусад баримт бичигт дурдсан шалгуурын үндсэн дээр манай оронд чөлөөт хэвлэлийн эх суурь тавигдаж, цаашид тууштай хөгжих бололцоо бүрдэж эхэлсэн боловч

хэвлэлийн хагас эрх чөлөөтэй орон мөн гэж үзсэн нь дэмжүүштэй санал юм.

Багш, судлаач Л.Норовсүрэн 1998 онд УИХ-аас батлагдсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хуулийн ач холбогдол, түүнийг хэрэгжүүлэх явцад учирч буй саад бэрхшээл, цаашид чөлөөт хэвлэлийн эрх зүйн орчин, сэтгүүлчдийн ёс зүйн хүрээнд шийдвэрлэх асуудлуудыг тодорхойлж, ёс зүйн алдаа гаргахад нөлөөлөх шалтгаан, хүчин зүйлүүдийг оновчтой тодорхойлсон нь практик ач холбогдлын хувьд чухал болсон гэж үзэж байна.

Энэхүү нэг сэдэвт зохиолын нэг чухал шинэлэг тал бол мэдээллийн шинэ хэрэгслүүд, сэтгүүл зүйн шинэ чиглэлүүд, тэдгээрийн төлөвшил, хэтийн төлөвийн талаар хийсэн дүгнэлт, шинэлэг санаа, практик зөвлөмж юм. Цахим хэвлэл мэдээлэл, рекламн сэтгүүл зүй, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, олон улсын сэтгүүл зүй, экологийн сэтгүүл зүй, иргэний сэтгүүл зүй, парламентийн сэтгүүл зүй, PR буюу олон нийтийн харилцааны талаарх шинэ хандлага, баримт мэдээллийг ашиглан дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргасан явдал юм. Сэтгүүл зүйн дээрх шинэ чиглэл, мэдээллийн хэрэгслүүдийн хөгжил, мэдээллийн агуулга хэлбэрт гарч байгаа өөрчлөлт шинэчлэл зэрэг нь Монголын сэтгүүл зүйн хөгжлийн өнөөгийн дүр төрх, хэтийн төлөвийг тодорхойлж, ардчилсан чөлөөт сэтгүүл зүй төлөвшин хөгжих нөхцөл хандлагыг илэрхийлж байгаа учир онол, практик, арга зүйн онцгой ач холбогдолтой юм. Л.Норовсүрэн өөрийнхөө судалгааны бүтээлд энэ асуудлыг анх удаа нэлээд өргөн хүрээнд авч үзээд, чухал дүгнэлт

гаргаж, санал дэвшүүлж байгаа нь нэг сэдэвт бүтээлийн үнэ цэнэ, ач холбогдлыг дээшлүүлж байна.

Дээр өгүүлсэн санаа бодлыг товч нэгтгэн дүгнэвэл энэ нэг сэдэвт зохиолын шинэлэг тал, ач холбогдол, сэтгүүл зүйн судлалд оруулсан хувь нэмэр нь дараах хэдэн зүйлд оршино. Үүнд:

- Монголын сэтгүүл зүйн үүсэл, хөгжлийн түүх, онол, практик, арга зүйн зангилаа асуудлуудыг цогц байдлаар авч үзээд сэтгүүл зүйн хөгжлийн түвшин, тулгамдсан асуудлууд, хэтийн төлөвийг шинжлэх ухааны үндэстэй, тал бүрээс нь нэгтгэн дүгнэсэн анхны оролдлого мөн.
- Монголын сэтгүүл зүйн түүхийг үнэн мөнөөр нь бичиж үлдээх, өөрөөр хэлбэл, үзэл суртлын хүлээснээс гаргаж зөвхөн түүхэн үнэнийг тодруулж, нотлохыг гол шугам болгон урьд өмнө судалгааны эргэлтэнд орж байгаагүй олон шинэ баримт мэдээллийг ашиглаж, дүн шинжилгээ хийж, сэтгүүл зүйн үүсэл, шинж чанар, онцлог, анхдагчдын талаарх хуучин тогтолцооны үеийн үзэл ойлголтыг эвдэж, цоо шинэ үндэслэл, нотолгоо гаргасан байна.
- Монголын хувьсгалт хэвлэлийн үүсэл хөгжил, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар шинэлэг санаа дэвшүүлж, ардчилсан нийгмийн үзэл баримтлалын үүднээс үнэлж дүгнэсэн нь анх удааны бөгөөд нэн шинэлэг болсон. Мөн хувьсгалт хэвлэлийн Монголын сэтгүүл зүйд оруулсан хувь нэмрийг тодорхой жишээ баримтад тулгуурлан цогц байдлаар гаргаж өгсөн анхны бүтээл юм.
- Манай оронд ОНМХ-ийн систем бүрэлдэн тогтсон онцлог шинж, үүнд нөлөөлсөн хүчин зүйлүүд, учирсан саад бэрхшээл зэргийг мэдээллийн

хэрэгсэл бүрийн онцлог шинжийг харгалзан үзэх замаар гаргаж өгсөн, шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт хийсэн, мөн 1990-ээд онд бий болсон ОНМХ-ийн системийн шинэ бүтцийг оновчтой тодорхойлж чадсан бүтээл мөн.

- Энэ бүтээлд ардчилсан нийгмийн үеийн сэтгүүл зүйн бүтэц, нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, ур чадвар, төрөл зүйлд гарсан эрс өөрчлөлт, сэтгүүл зүйн шинэ чиглэлүүд, шинэ мэдээллийн хэрэгслүүд бүрэн тусгагдсаны дээр Монголын сэтгүүл зүйн түүхэн хэв маягуудын онолын зарчим, үүрэг, зорилтыг харьцуулан авч үзээд, урьд өмнө манай орны сэтгүүл зүйн судлаачдын хийж байгаагүй цоо шинэ онолын дүгнэлт хийж, үзэл баримтлалыг дэвшүүлэн тавьснаараа үнэ цэнэтэй болжээ.
- Манай оронд чөлөөт хэвлэл төлөвшиж буй онцлог, тулгамдсан асуудлууд, учирч буй саад бэрхшээл, тэдгээрийг шийдвэрлэх арга зам болон чөлөөт хэвлэлийн шалгуур, онолын үзэл баримтлалыг бусад оронтой харьцуулах замаар дүгнэлт хийж, тодорхой санал зөвлөмж дэвшүүлсэн нь Монголын сэтгүүл зүйн судлал дахь нэн шинэлэг хандлага мөн. Эцэст нь тэмдэглэхэд доктор, профессор Ломбын Норовсүрэнгийн “Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм” гурван боть бүтээл, түүнээс гарсан дүгнэлтүүдийн цогц болсон “Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд” нэг сэдэвт зохиол нь “Монголын сэтгүүл зүйн онол, түүхийг хавсран судалж, ерөнхий дүр зургийг гаргахын хамт улс орны хөгжлийн янз бүрийн үе шатанд ОНМХ-ийн гүйцэтгэсэн үүргийг тодорхойлж, хуримталсан туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэж, зангилаа асуудлуудыг тодруулахад

оршино” гэсэн үндсэн зорилгыг бүрэн биелүүлж, Монголын сэтгүүл зүйн судлалд жинтэй хувь нэмэр оруулсан дорвитой бүтээл болжээ.

Хоёр. Бичлэгийн төрөл, зүйлийн талаар шинэ үг хэлж, шинэлэг санаа дэвшүүлсэн бүтээл

Профессор Л.Норовсүрэнгийн өөр нэг судалгааны сонирхолтой бүтээл бол 1996 онд сэтгүүл зүйн докторын зэрэг горилон бичсэн “Тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлийн онол, практикийн асуудлууд” хэмээх нэг сэдэвт зохиол юм. 1995 онд Боловсролын сайдын тушаалаар МУИС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн дэргэд Сэтгүүл зүйгээр докторын зэрэг хамгаалуулах зөвлөл анх байгуулагдсан бөгөөд тус зөвлөлд докторын зэрэг хамгаалсан анхны судлаач бол Л.Норовсүрэн юм.

Л.Норовсүрэн багшийн энэ бүтээл нь 1990-ээд оны эхний үед сэтгүүл зүйн бичлэгийн төрөл, зүйл хямралд орж, бичлэгийн төрөл зүйл байна, байхгүй, хэрэгтэй, хэрэггүй гэсэн ширүүн маргаан өрнөж байсан, чөлөөт сэтгүүл зүйн эх суурь дөнгөж тавигдаж эхэлсэн үед бичигдэж, энэ сэдвээр цэвэр сэтгүүл зүйн эрдмийн зөвлөлд докторын зэрэг хамгаалсан нь нэг талаар, маргаантай олон асуудалд шинжлэх ухааны үндэстэй хариулт өгч, нөгөө талаар сэтгүүл зүй бие даасан шинжлэх ухаан мөн гэдгийн баталгаа болж чадсаны илрэл юм. Тиймээс доктор, профессор Ц.Сүхбаатар “Л.Норовсүрэнгийн бүтээлд хэн ч маргашгүй нэг том ололт бий. Өнөөдөр сэтгүүлчид, сонин хэвлэлийнхэн төрөл зүйл байна, байхгүй хэмээн бужигнаж, практик ажил дээрээ ч хэрэглэсэн хэрэглээгүй хоёрын хооронд болчихлоо. Ийм үед бичлэгийн төрөл, зүйл гэдэг чинь утга зохиолын бүтээлийн

хэвшиж тогтсон хэлбэр шүү, түүнд чинь бас хэм хэмжээ гэж байдаг юм шүү гэдгийг тогтоож өгснөөрөө том ололт юм. Энэ бол уг бүтээлийн шинжлэх ухааны ач холбогдол, үнэ цэнэ мөн”⁶ гэж онцлон тэмдэглэсэн нь санамсаргүй зүйл биш юм.

Зохиогчийн эл бүтээл нь бүтцийн хувьд Монголын тогтмол хэвлэлд бичлэгийн төрөл, зүйл төлөвшсөн түүхэн тоймыг авч үзээд, түүнийгээ задлан, бичлэгийн зүйлүүдийг мэдээллийн, шинжлэлт, нийтлэл-уран сайхны гэсэн гурван төрөлд ангилж, зүйл тус бүрийн үүсч хөгжсөн, төгөлдөржин боловсорсон байдлыг орчин үеийн хандлагатай нь хамт цухас цухас дурдаж, бүлэг бүрийн эцэст тухайн төрөлд багтах зүйлүүдийн талаар товч дүгнэлт хийж, эцэст нь нэг сэдэвт зохиолоос гарах гол дүгнэлтээ тусгайлан хийсэн нь арга зүйн хувьд оновчтой, шинжлэх ухааны үндэстэй болсныг харуулж байна. Бүтээлийн “Мэдээллийн бичлэгийн төрөл бол сэтгүүл зүйн мэргэжлийн шалгуур мөн” хэмээх нэгдүгээр бүлэгт сонины бичлэгийн төрөл, зүйлийн тухай ерөнхий ойлголт өгч мэдээгээс сурвалжилсан тэмдэглэл хүртлэх энэ ангилалд багтах бүх бичлэгийн зүйлүүдийг нэгбүрчлэн авч үзээд тодорхой жишээ баримтуудад үндэслэн задлан шинжилж, нэгтгэн дүгнэж онол, арга зүйн шинжтэй үнэлэлт дүгнэлт өгсөн нь нэн шинэлэг болжээ. Зохиогч “...сонин сэтгүүлийн хөгжлийн явцад бие биеэсээ ялгарах шинж тэмдэг, онцлогтой болсон, бодит амьдралыг шуурхай тусгах өвөрмөц арга бүхий нийтлэлийн утга зохиолын тогтвортой хэлбэрүүдийг сонины бичлэгийн төрөл, зүйл хэмээн тодорхойлж байна. ...Сонин сэтгүүлийн бичлэгийн зүйл бие биенээсээ ялгарах онцлог шинжтэй боловч цэвэр жанр гэж

байдаггүй. Ер нь сонины бичлэгийн зүйлүүд харилцан бие биенээсээ урган гарсан, усан орсон шинж чанартай байдаг. ...сонин сэтгүүлд нийтлэгдэж байгаа бүх бичлэгийг илүү адил төстэй шинжүүдээр нь бүлэглэснийг бичлэгийн төрөл, нэг төрөлд багтаж байгаа тусгай бичлэгийг зүйл, зүйл доторх бичил ангиллыг хэлбэр хэмээн үзнэ”⁷ гэсэн үндэслэл сайтай, оновчтой дүгнэлт хийсэнтэй санал нэг байна. Эл тодорхойлолт дүгнэлтийг зөвхөн тогтмол хэвлэлд төдийгүй ОНМ-ийн бусад бүх хэрэгсэлд шууд хэрэглэх боломжтой гэдэг нь ойлгомжтой юм.

Бүтээлийн “Шинжлэлт бичлэгийн төрөл бол үр нөлөөний хөшүүрэг мөн” хэмээх хоёрдугаар бүлэгт өгүүлэл, хэвлэлийн тойм, шүүмж, эссе зэрэг шижлэлт бичлэгийн зүйлүүдийг нэлээд нухацтай авч үзээд манай сэтгүүл зүйн судалгаанд олон жилийн турш хэвшмэл болсон зарим онолын ойлголтуудыг гүнзгийрүүлэн тайлбарлаж, өөрийнхөө шинэ бодол санаагаар баяжуулсан нь шинэлэг бөгөөд дэмжүүштэй эхлэл юм. Хэрэв зохиогч судалгааны бүтээлийн нэгдүгээр бүлэгт бичлэгийн зүйл бүрт тусгайлан дүн шинжилгээ хийхийн сацуу мэдээлийн бичлэгийн төрөл бол сэтгүүл зүйн мэргэжлийн шалгуур болох шалтгаан, үндэслэлийг нэн оновчтой тайлбарласан бол хоёрдугаар бүлэгт шинжлэлт буюу аналитик бичлэгийн төрөл нийтлэлийн үр нөлөөний хөшүүрэг болох учир, шалтгааныг дэлгэрэнгүй тайлбарласан нь сэтгүүл зүйн онол, практикийн хувьд чухал ач холбогдолтой зүйл болжээ. Мөн зохиогч эссе “төрөгдөл” гэж нэрлэх санал дэвшүүлж, түүний учир шалтгааныг “Монгол хэлэнд хүний мэдрэх, сэтгэх үйлдлийг үзүүлсэн сэтгэх-сэтгэгдэх, төрөх-төрөгдөх, бодох-бодогдох, үзэх-үзэгдэх зэрэг

үгийн үйлдэгдэх хэвээс “л” дагавраар үүсгэсэн сэтгэгдэл, төрөгдөл гэдэг нэр бий. “Эссе” нь латин хэлний “эргэцүүлэн бодох” гэсэн утгатайг бодсон ч, ерөөсөө уг зүйл нийгмийн чухал асуудлын талаар зохиогчийн сэтгэлд төрөгдсөн бодол санаа байдгийг харгалсан ч “төрөгдөл” гэсэн монгол үгээрээ нэрлэж занших нь будлиангүй болох мэт санагдана”⁸ гэж тайлбарласныг шууд хүлээж авахад эргэлзээтэй боловч харгалзан үзүүштэй, ОНМХ-ийн практикт хэвшүүлж болмоор санаа юм. Энэ мэтийн шинэ санаа, шинэлэг үнэлэлт дүгнэлт, санал зөвлөмж Л.Норовсүрэн докторын бүтээлд олон байгаа нь түүний бүтээлч сэтгэлгээ, эрэл хайгуул, бодол эргэцүүлийн илрэл юм.

Нэг сэдэвт зохиолын “Нийтлэл уран сайхны бичлэгийн төрөл” хэмээх гуравдугаар бүлэгт найруулал, тэмдэглэл, уран нийтлэл, шог найруулал, улс төрийн шог зэрэг бичлэгийн зүйлүүдэд дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгчээ. Энэ бүлгийн гол ололт нь урьд өмнө маш бага судлагдсан, зайлшгүй гүнзгийрүүлэн судлах шаардлагатай тэмдэглэл, уран нийтлэл хэмээх хоёр бичлэгийн зүйлийг дэлгэрэнгүй авч үзээд, асуудалд арай өөр өнцгөөс хандаж, цоо шинэ дүгнэлт хийж, шинэ санаа дэвшүүлсэнд оршино. Зохиогч “тэмдэглэл бол үндэсний уламжлалтай бичлэгийн зүйл гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй”⁹, “уран нийтлэл нь манай сэтгүүл зүйн хөгжлийн түүхэнд гарсан ололт, содон үзэгдэл төдийгүй бичлэгийн өвөрмөц дайчин зүйл мөн”¹⁰ гэж дүгнээд, тэмдэглэлийг мэдээлсэн, шүүмжилсэн, үйл явдлын, аян замын, дурсамж гэсэн таван хэлбэрт, уран нийтлэлийг сэдвийн хувьд дэлхий нийтээр ёслон тэмдэглэдэг томоохон

үйл явдлын сэдэвтэй, найрамдал нөхөрлөлийн сэдэвтэй, өдөр тумын амьдралын сэдэвтэй гэж ангилсан нь үндэслэлтэй, оновчтой дүгнэлт бөгөөд цаашид улам гүнзгийрүүлэн судалж баяжуулах шаардлагатай юм.

Манай орны тогтмол хэвлэлд бичлэгийн төрөл, зүйл үүсч, хөгжсөн байдлыг онол, практикийн талаас нь нэгтгэн дүгнэж, ялангуяа орчин үед энэ чиглэлээр гарч байгаа өөрчлөлтийн нийгэм, сэтгэл зүйн үндсийг тусгах зорилт тавьсанд энэхүү судалгааны ажлын ач холбогдол оршиж байна.

Монголын сэтгүүл зүй түүхийн талаасаа нэлээд сайн судлагдаж, тоймтой тулгуур бүтээлүүд гарч, Г.Дэлэг, Т.Баасансүрэн, Т.Галдан, Ч.Алагсай, Х.Лхамдорж зэрэг хэд хэдэн судлаач эрдмийн зэрэг горилсон бүтээл туурвисан юм. Харин сэтгүүл зүйн шинжлэх ухааны

онол, практикийн гол цөм болсон сэтгүүлчийн ур чадвар, бичлэгийн төрөл зүйлийн асуудлыг дангаар нь гүнзгийрүүлэн судалсан бүтээл өнөөг хүртэл гараагүй болохоор Л.Норовсүрэн судлаачийн энэ бүтээл шинэ зам гаргасан эрэлт хэрэгцээтэй бүтээл болсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Ер нь шинжлэх ухааны доктор, профессор Л.Норовсүрэнд судлаач хүнд байдаг, залуу судлаачид анхаарч суралцах, үлгэр дууриал авах учиртай хэд хэдэн чухал чанар байдгийг олон

жил хамт ажиллаж, сургалтын хөтөлбөр, сурах бичиг, гарын авлага, судалгааны төсөл зэрэг цөөнгүй бүтээлийг хамтран бичиж, боловсруулж байсан хүний хувьд энд зориуд тэмдэглэхийг хүсч байна. Тэрээр маш хөдөлмөрч, цагаа зөв, үр бүтээлтэй ашиглаж чаддаг, өмнөө тавьсан зорилгын ард заавал гарч байж санаа нь амардаг хүн. Үүний тод жишээ бол Монголын сэтгүүл зүйн 100 гаруй

жилийн түүхийг, Монголын нийтлэлийн хөгжил, төлөвшлийн түүх, онол, практикийн асуудлыг багтаасан 6 боть судалгааны бүтээл юм. Ийм нүсэр ажлыг гадаад орнуудад бүхэл бүтэн судалгааны хүрээлэн, эсвэл судлаачдын томоохон баг цөөнгүй жил судалж байж бүтээдэг. Тэвэл ийм ажлыг проф.

Л.Норовсүрэн олон жил уйгагүй судалж, ганцаараа

гүйцэтгэж чадсан юм. Үүнийг Л.Норовсүрэнээс өөр хүн ганцаараа гүйцэтгэж чадна гэдэгт миний бие эргэлздэг.

Дүгнэлт

Профессор Л.Норовсүрэн Монголын сэтгүүл зүйн түүх болон нийтлэлийн уламжлал, төлөвшил, шинэчлэлийн асуудлыг иж бүрэн судалж, Монголын сэтгүүл зүйн судлал, тэр дундаа ОНМХ-ийн түүхийн судалгаанд жинтэй хувь нэмэр оруулсан томоохон эрдэмтэн. Түүний шинжлэх ухааны



Проф. Л.Норовсүрэн Монголын сэтгүүл зүйн түүхийн судалгааг шинэ шатанд гаргасан эрдэмтэн төдийгүй сэтгүүл зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэх, ОНМХ-ийн практикийн болон арга зүйн асуудлуудыг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач юм. Ухамсарт амьдралынхаа хагас зуун жилийг Монголын сэтгүүл зүйн хөгжил, сургалт, судалгааны ажилд зориулж яваа шинэжлэх ухааны доктор, профессор, нэрт сурган хүмүүжүүлэгч Ломбын Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн судлалын ноён оргилуудын нэг



докторын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл нь сэтгүүл зүйн өнгөрсөн үеийн үндсэн асуудлуудыг хамруулж, түүний нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, хуримтлуулсан туршлага, уламжлал, шинэчлэлийг тодруулж, цаашдын төлөвийг тодорхойлохын зэрэгцээ Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлуудыг анх удаа бүрэн хэмжээгээр авч үзэн, эрдэм шинжилгээний үүднээс дүгнэсэнд бүтээлийн шинэлэг тал, онол, практикийн ач холбогдол оршино.

Түүний докторын зэрэг горилж бичсэн бүтээл нь Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлийн асуудлыг түүх, онол, практик, арга зүйн үүднээс иж бүрэн авч үзсэн анхны бүтээл бөгөөд цаашид энэ асуудлыг улам нарийвчилж, гүнзгийрүүлэн судлах үүд хаалгыг нээж өгснөөрөө сэтгүүл зүйн судлалд томоохон хувь нэмэр оруулсан судалгааны бүтээл юм. Үүний тод жишээ бол өнөөдөр мэдээ, ярилцлага, хошин шог бичлэгийн төрөл, зүйлээр хэд хэдэн хүн эрдмийн зэрэг хамгаалсан явдал мөн.

Проф. Л.Норовсүрэн Монголын сэтгүүл зүйн түүхийн судалгааг шинэ шатанд гаргасан эрдэмтэн төдийгүй сэтгүүл зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэх, ОНМХ-ийн практикийн болон арга зүйн асуудлуудыг боловсруулахад үнэтэй хувь нэмэр оруулсан судлаач юм. Түүний “Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд”, “Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлийн онол, практикийн асуудлууд”, “Иргэний сэтгүүл зүй”, “Сэтгүүл зүйн онол, түүхийн асуудлууд” зэрэг томоохон бүтээлүүдээс гадна “Телевизийн сэтгүүл зүй”, “Радио сэтгүүл зүй” зэрэг сурах бичиг, хэд хэдэн хамтын бүтээлүүд болон олон тооны эрдэм шинжилгээний

өгүүллүүдэд ОНМХ-ийн үүрэг, зарчим, сэтгүүлчийн ур чадвар, нийтлэлийн үр нөлөө ба үр ашиг, сэтгүүл зүйн шинэ чиглэлүүдийн талаар шинжлэх ухааны үндэстэй, даацтай онолын дүгнэлтүүдийг хийсэн байдаг. Энэ бүхнээс үзэхэд ухамсарт амьдралынхаа хагас зуун жилийг Монголын сэтгүүл зүйн хөгжил, сургалт, судалгааны ажилд зориулж яваа шинжлэх ухааны доктор, профессор, нэрт сурган хүмүүжүүлэгч Ломбын Норовсүрэн бол Монголын сэтгүүл зүйн судлалын ноён оргилуудын нэг бөгөөд ирэх он жилүүдэд Монголын сэтгүүл зүйн төлөө их юм хийж, олон сайхан бүтээлээрээ биднийг баярлуулж явна гэдэгт дөчөөд жил хамт ажиллаж буй үзэг нэгт нөхрийн хувьд итгэлтэй байна.

Ишлэл

- ¹Лигдэн Б. Түүхийн гажуудлыг залруулж, хоосон зайг нөхсөн бүтээл // “Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Л.Норовсүрэн”. УБ., 2013. х.129-130.
- ² Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд (Шинжлэх ухааны докторын диссертаци). УБ., 2004. х.110.
- ³ Цэнд-Аюуш Ш. Маргаантай асуудлыг нэг мөр болгосон эрдэмтэн // “Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Л.Норовсүрэн”. УБ., 2013. х.137.
- ⁴ Норовсүрэн Л. Дурдсан бүтээл... х.190.
- ⁵ Мөн тэнд. х.206.
- ⁶Сүхбаатар Ц. Анхны эрдэмтэн төрж байгаад баяртай байна //“Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Л.Норовсүрэн”. УБ., 2013. х.117.
- ⁷ Норовсүрэн Л. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 1996. х.13, 15-16.
- ⁸ Мөн тэнд. х.86-87.
- ⁹ Мөн тэнд. х.113.
- ¹⁰Мөн тэнд. х.130.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. Монголын сэтгүүл зүйн шүүмж судлал: Сэтгүүл зүйн судлаач, нийтлэлч Ломбын Норовсүрэн. УБ. 2013.
2. Зулькафиль М. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть Х. УБ., 2017.
3. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. УБ. Боть I, II, III. 2000-2003.
4. Норовсүрэн Л. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйлийн онол, практикийн асуудлууд. Док. дисс... УБ., 1996.
5. Норовсүрэн Л. Монголын тогтмол хэвлэлийн бичлэгийн төрөл, зүйл. УБ., 1996.
6. Норовсүрэн Л. Монголын сэтгүүл зүйн онол, түүхийн тулгуур асуудлууд. Шинжлэх ухааны докторын дисс... УБ. 2004.

Резюме

Автор в статье анализируя основные научные труды доктора филологических наук, профессора, Заслуженного деятеля культуры Монголии Л.Норовсүрэна делает вывод о том, что он является не только крупным исследователем истории монгольской журналистики, но и видным ученым -теоретиком современной журналистики. Автор считает, что ярким примером этого являются его докторская диссертация “Основные проблемы теории и истории монгольской журналистики” и кандидатская диссертация “Некоторые теоретико-практические проблемы жанров периодической печати Монголии”, где автор впервые комплексно исследовал теоретико-методологические вопросы жанров периодической печати и мастерства монгольских журналистов.